



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/249

Улаанбаатар хот

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Монгол Улсын Засгийн газар ба Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн Сангийн хооронд 2003 онд байгуулсан "Худалдан авах үйл ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг", Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор батлагдсан "Хүн амын хоол тэжээл" үндэсний хөтөлбөрийн 4.2.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. НҮБ-ын Хүүхдийн сангийн төсөл хэрэгжүүлж байгаа зарим аймаг, дүүргийн Хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл түгээх хуваарийг нэгдүгээр, Жин, өндөр хэмжигч, бугалганы тойрог хэмжигч түгээх хуваарийг хоёрдугаар, Хоол тэжээлийн цочмог дутлын эмчилгээний бэлдмэл түгээх хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хуваарийн дагуу түгээлт хийж, тайланг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
3. Хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Г.Энхзаяа/-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080783

Эрүүл мэндийн сайдын
 2019 оны...*05*... сарын *27*... өдрийн
А/Б/19 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**Хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан
 олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл түгээх хуваарь**

Д/д	Аймаг, сум	Хүүхдэд зориулсан ОНБТБ		Жирэмсэн эмэгтэйд зориулсан аминдэм, эрдсийн бэлдмэл	
		Хүүхдийн тоо	Хайрцаг (1 хайр 30 ш)	Эмэгтэйчүүдийн тоо	Хайрцаг (1 хайрцаг 1000 ш)
1	Баянхонгор	2,981	7,000	891	73
2	Говь-Алтай	1,779	4,200	513	42
3	Завхан	2,383	5,600	718	60
	Нийт	7,143	16,800	2,122	175

Эрүүл мэндийн сайдын
2019 оны ...05... сарын 27... өдрийн
А/мчг дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Жин, өндөр хэмжигч,
бугалганы тойрог хэмжигч түгээх хуваарь

Д/ Д	Хуваарилах газрууд	Жин, электрон	Өндөр хэмжигч	Бугалганы тойрог хэмжигч		Нярайн жин
				хүүхэд	Том хүн	
1	Баянхонгор	-	26	37	51	-
2	Говь-Алтай	-	21	32	46	-
3	Завхан	12	33	37	51	1
4	Баянзүрх дүүрэг	-	-	37	51	-
5	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	3	5	5	5	-
	Нийт	15	85	148	204	1

Эрүүл мэндийн сайдын
2019 оны ...*05*... сарын *27*... өдрийн
А/249 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



**Хоол тэжээлийн цочмог дутлын
эмчилгээний бэлдмэл түгээх хуваарь**

д/д	Хуваарилах газрууд	Эмчилгээний нухаш	Рисомал
1	Баянзүрх дүүрэг	65	3
2	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	75	3
3	Нялхсын сувилал	59	2
4	Өвөрхангай аймаг	30	2
	Нийт	229	10